

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орон нутгийн судлах музейн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **ЗАА-2022/215/СТА-ТШЗ**

Цахим хуудас:

www.audit.mn

Улиастай сум

2022 он

Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын
тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа
Утас: 99993365
Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежерийн үүргийг түр
орлон гүйцэтгэгч : Г.Заяа
Утас:92038288
Цахим хаяг: zayag@audit.gov.mn

Интер аудит ХХК
Гэрээт аудитор: Г.Алтанцэцэг
Утас: 99469299, 90111091
Цахим хаяг: altan_fin@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.6.1 Төсвийн төлөвлөлт	13
3.6.2 Төсвийн гүйцэтгэл.....	13
3.6.3 Нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт	14
4.1 Засварын үеийн санхүүгийн тайлангийн аудит.....	14
4.2 Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудит	14
4.2.1 Залруулсан алдаа.....	15
4.2.2 Төлбөрийн акт.....	15
4.2.3 Албан шаардлага	15
4.2.4 Зөвлөмж	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТАХ	Төрийн албан хаагч

1.Аудитын санал дүгнэлт



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81000 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс:7046-36-12

2022. 02. 21 № 1202/77

танай _____ -ны № _____ -т

ОРОН НУТГИЙН СУДЛАХ МУЗЕЙН
ДАРГА Ж.ЮНРЭНДОРЖ-д

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орон нутгийн судлах музейн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орон нутгийн судлах музейн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

012022991

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/мянган төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>27,858.00</u>	<u>27,724.71</u>
33	АВЛАГА	59.85	1,449.27
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	1,410.21
335	Бусад авлага	59.85	39.06
3351	Байгууллагаас авах авлага	59.85	39.06
35	БАРАА МАТЕРИАЛ	27,798.15	26,275.44
354	Хангамжийн материал	27,798.15	26,275.44
35410	Бичиг хэргийн материал	6,416.87	6,570.87
35420	Аж ахуйн материал	15,443.16	14,407.86
35430	Сэлбэг хэрэгсэл	904.00	774.00
35450	Барилгын засварын материал	5,034.11	4,522.70
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,481,353.86</u>	<u>1,465,784.78</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,481,353.86	1,465,784.78
392	Биет хөрөнгө	1,464,203.86	1,448,634.78
39201	Барилга, байгууламж, орон сууц	353,498.85	353,498.85
39202	Хуримтлагдсан элэгдэл	(43,263.10)	(62,070.45)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	34,799.20	34,799.20
39204	Хуримтлагдсан элэгдэл	(34,799.20)	(34,799.20)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	83,373.63	82,205.63
39206	Хуримтлагдсан элэгдэл	(67,564.28)	(67,751.25)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	56,150.31	56,150.31
39208	Хуримтлагдсан элэгдэл	(35,498.91)	(40,545.66)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	1,117,507.36	1,127,147.36
393	Биет бус хөрөнгө	17,150.00	17,150.00
39301	Програм хангамж	5,650.00	5,650.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(5,650.00)	(5,650.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	17,150.00	17,150.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,509,211.86</u>	<u>1,493,509.50</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>0.10</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	0.10
413	Өглөг	-	0.10
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	0.10
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,509,211.86</u>	<u>1,493,509.40</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,509,211.86	1,493,509.40
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,231,031.86	1,231,031.86
51101	Өмч: - төрийн	1,231,031.86	1,231,031.86
512	Хуримтлагдсан үр дүн	(753,343.62)	(769,046.08)
51210	Өмнөх үеийн үр дүн	(753,343.62)	(753,343.62)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(15,702.46)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,031,523.62	1,031,523.62
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,509,211.86</u>	<u>1,493,509.50</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/мянган төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	316,725.70	301,190.34
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,100.00	9,640.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,100.00	9,640.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,100.00	9,640.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,100.00	9,640.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	315,625.70	291,550.34
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	11,825.80	34,545.94
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	4,817.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	2,871.50
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,008.80	31,674.44
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	303,799.90	257,004.40
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	303,799.90	257,004.40
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	339,297.23	316,892.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	339,297.23	316,892.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	289,101.73	280,023.87
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	161,466.34	155,947.80
210101	Үндсэн цалин	121,708.74	124,289.15
210102	Нэмэгдэл	28,417.60	21,658.43
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,340.00	10,000.22
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,938.31	21,095.96
210201	Тэтгэврийн даатгал	14,426.45	14,742.30
210202	Тэтгэмжийн даатгал	1,697.27	1,631.51
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,283.89	1,262.22
210204	Ажилгүйдлийн даатгал	320.97	314.53
210205	Эрүүл мэндийн даатгал	3,209.73	3,145.39
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	65,280.30	63,279.96
210301	Гэрэл, цахилгаан	1,885.18	1,138.23
210302	Түлш, халаалт	61,758.11	61,638.40
210303	Цэвэр, бохир ус	1,637.01	503.33
2104	Хангамж, бараа материалын зардал	3,068.35	4,591.83
210401	Бичиг хэрэг	701.10	632.93
210402	Тээвэр, шатахуун	1,595.55	1,653.89
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	771.70	661.01
210408	Бараа материал акталсны зардал	-	1,644.00
2105	Нормативт зардал	491.75	579.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	491.75	579.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,109.95	1,975.51
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	80.00	-
210604	Урсгал засвар	3,029.95	1,975.51
2107	Томилолт, зочны зардал	865.50	865.50
210702	Дотоод албан томилолт	865.50	865.50
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,130.44	4,974.13
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,267.29	4,436.53
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432.00	250.00
210803	Даатгалын үйлчилгээ	94.00	94.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	114.00	110.00
210807	Газрын төлбөр	154.35	14.80
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	68.80	68.80
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,750.78	26,714.17
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	355.10	355.10
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	25,395.68	26,359.07
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	50,195.50	36,868.94
2132	Бусад урсгал шилжүүлэг	20,846.86	29,348.64
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,446.86	28,848.64
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,400.00	500.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	29,348.64	7,520.30
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	29,348.64	7,520.30
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(22,571.53)	(15,702.46)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(22,571.53)	(15,702.46)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,231,031.86	1,032,282.02	(731,530.49)	1,531,783.39
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	758.40	758.40
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,231,031.86	1,032,282.02	(730,772.09)	1,532,541.79
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(22,571.53)	(22,571.53)
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,231,031.86	1,031,523.62	(753,343.62)	1,509,211.86
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,231,031.86	1,031,523.62	(753,343.62)	1,509,211.86
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,231,031.86	1,031,523.62	(753,343.62)	1,509,211.86
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(15,702.46)	(15,702.46)
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,231,031.86	1,031,523.62	(769,046.08)	1,493,509.40

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>315,625.70</u>	<u>291,550.34</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	315,625.70	291,550.34
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	11,825.80	34,545.94
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	4,817.00	-
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	2,871.50
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,008.80	31,674.44
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	303,799.90	257,004.40
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	303,799.90	257,004.40
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>315,625.70</u>	<u>290,400.34</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	315,625.70	290,400.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	265,430.20	253,531.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	161,466.34	157,357.91
210101	Үндсэн цалин	121,708.74	125,699.25
210102	Нэмэгдэл	28,417.60	21,658.43
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,340.00	10,000.22
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,913.06	21,095.97
210201	Тэтгэврийн даатгал	14,401.19	14,742.30
210202	Тэтгэмжийн даатгал	1,697.27	1,631.51
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,283.89	1,262.22
210204	Ажилгүйдлийн даатгал	320.97	314.54
210205	Эрүүл мэндийн даатгал	3,209.73	3,145.39
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	65,280.30	63,279.96
210301	Гэрэл, цахилгаан	1,885.18	1,138.23
210302	Түлш, халаалт	61,758.11	61,638.40
210303	Цэвэр, бохир ус	1,637.01	503.33
2104	Хангамж, бараа материалын зардал	2,994.70	3,141.04
210401	Бичиг хэрэг	567.60	786.93
210402	Тээвэр, шатахуун	1,655.40	1,633.10
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	771.70	661.01
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	60.00
2105	Нормативт зардал	1,110.25	619.30
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,110.25	619.30
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,342.50	1,842.50

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	300.00	300.00
210604	Урсгал засвар	3,042.50	1,542.50
2107	Томилолт, зочны зардал	865.50	865.50
210702	Дотоод албан томилолт	865.50	865.50
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,102.44	4,974.13
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,239.29	4,436.53
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432.00	250.00
210803	Даатгалын үйлчилгээ	94.00	94.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	114.00	110.00
210807	Газрын төлбөр	154.35	14.80
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	68.80	68.80
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	355.10	355.10
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	355.10	355.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	50,195.50	36,868.94
2132	Бусад урсгал шилжүүлэг	20,846.86	29,348.64
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,446.86	28,848.64
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,400.00	500.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	29,348.64	7,520.30
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	≡	<u>1,150.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	1,150.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	1,150.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	1,150.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	1,150.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	≡	<u>(1,150.00)</u>

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	257,004.40	257,004.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	257,004.40	257,004.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	256,504.40	252,559.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	160,686.70	157,357.91
210101	Үндсэн цалин	120,929.10	125,699.25
210102	Нэмэгдэл	28,417.60	21,658.43
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,340.00	10,000.22
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,692.70	21,095.97

210201	Тэтгэврийн даатгал	15,265.20	14,742.30
210202	Тэтгэмжийн даатгал	1,606.90	1,631.51
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,285.50	1,262.22
210204	Ажилгүйдлийн даатгал	321.40	314.54
210205	Эрүүл мэндийн даатгал	3,213.70	3,145.39
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	63,280.30	63,279.96
210301	Гэрэл, цахилгаан	2,331.60	1,138.23
210302	Түлш, халаалт	59,998.30	61,638.40
210303	Цэвэр, бохир ус	950.40	503.33
2104	Хангамж, бараа материалын зардал	2,994.70	2,994.28
210401	Бичиг хэрэг	567.60	786.93
210402	Тээвэр, шатахуун	1,655.40	1,633.10
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	771.70	574.25
2105	Нормативт зардал	619.30	619.30
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	619.30	619.30
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,842.50	1,842.50
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	300.00	300.00
210604	Урсгал засвар	1,542.50	1,542.50
2107	Томилолт, зочны зардал	865.50	865.50
210702	Дотоод албан томилолт	865.50	865.50
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,167.60	4,149.13
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,626.00	3,611.53
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250.00	250.00
210803	Даатгалын үйлчилгээ	94.00	94.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	114.00	110.00
210807	Газрын төлбөр	14.80	14.80
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	68.80	68.80
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	355.10	355.10
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	355.10	355.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	500.00	4,444.76
2131	Засгийн газар хоорондын шилжүүлэг	-	3,944.76
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	3,944.76
2132	Бусад урсгал шилжүүлэг	500.00	500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500.00	500.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	257,004.40	257,004.40
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	257,004.40	257,004.40
132001	Орон нутгийн төсвөөс	257,004.40	257,004.40
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	0.015	0.015
620001	Удирдах ажилтан	0.001	0.001
620002	Гүйцэтгэх ажилтан	0.008	0.008
620003	Үйлчлэх ажилтан	0.006	0.006
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	0.015	0.015
650006	Соёл урлагийн салбарын терийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	0.007	0.007
650009	Терийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	0.008	0.008

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	34,545.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	34,545.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,121.76
2104	Хангамж, бараа материалын зардал	1,296.76
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	86.76
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,210.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	825.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	825.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32,424.18
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	3,575.54
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	3,575.54
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,848.64
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	28,848.64
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	34,545.94
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	34,545.94
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,871.50
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	31,674.44

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Орон нутгийг судлах музейн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллага нягтлан бодох бүртгэл, тайлагнал, худалдан авалт, арвилан хэмнэлт зэрэгтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Интер аудит ХХК-ийн гэрээт аудитор Г.Алтанцэцэг, Интер Аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал Ч.Мөнхбаяр нар гүйцэтгэж, хяналтыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Заяа, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Орон нутгийг судлах музейн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн № 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Орон нутгийг судлах музей нь соёлын үнэт зүйлийг бүртгэх, цуглуулах, хадгалж хамгаалах, судлах, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх чиг үүрэг бүхий ашгийн төлөө бус соёл, эрдэм шинжилгээний байгууллага юм. 2021 онд 12 зорилт дэвшүүлснээс 97.75 хувийн биелэлттэй ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллага нь боловсролын системийн байгууллагын хүрээнд дагаж мөрддөг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүү үйл ажиллагаандаа дагаж мөрддөг, дотоод хяналтыг хэрэгжүүлэх журам, заавар зэргийг боловсруулж мөрдөөгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орон нутгийг судлах музейн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалтай гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны төсвийн гүйцэтгэлийн 257.0 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 3.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлыг 75 хувь буюу 2.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	59.85	1,449.27	1,389.42
Бараа материал	27,798.15	26,275.44	(1,522.71)
Үндсэн хөрөнгө	1,481,353.86	1,465,784.78	(15,569.07)
Нийт хөрөнгө	1,509,211.86	1,493,509.50	(15,702.36)
Өр төлбөр	-	0.10	0.10
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,509,211.86	1,493,509.40	(15,702.46)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,509,211.86	1,493,509.50	(15,702.36)

Авлага дансны үлдэгдэл 1.4 сая төгрөгөөр өссөн нь ажиллагсадтай холбоотой авлага нэмэгдсэнтэй холбоотой.

Бараа материалын дансны үлдэгдэл 1.5 сая төгрөгөөр буурсан нь 6.7 сая төгрөгийн хангамжийн материал худалдан авч 6.6 сая төгрөгийн бараа материал зарцуулсан, 1.6 сая төгрөгийн аж ахуйн материал, сэлбэг хэрэгсэл ақталсан зэрэгтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 15.6 сая төгрөгөөр буурсан нь 1.1 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч, хандиваар 9.6 сая төгрөгийн түүх, соёлын дурсгалт зүйл нэмэгдэж, 26.4 сая төгрөгийн элэгдлийн зардал гарсантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 0.10 мянган төгрөгөөр өссөн нь ажиллагсадтай холбоотой өглөгтэй үүссэнтэй холбоотой.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 15.7 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 257.0 сая төгрөгөөр, нийт зарлагыг 257.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 257.0 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 253.1 сая төгрөгийг зарцуулж 3.9 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр дээд шатны төсвийн захирагчаас 2.9 сая төгрөгийн, улсын төсвөөс 31.6 сая төгрөгийн, нийт 34.5 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч, 2.1 сая төгрөгийг бараа, үйлчилгээний зардалд, 28.8 сая төгрөгийг тэтгэмжид зарцуулж, 3.6 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Онцолсон болон бусад асуудал гараагүй.

3.8 Аудитын гол асуудал

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

2021 онд нийт 147 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 147 мэдээг хугацаанд байршуулсан боловч Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээ, санхүүжилтийн хэмжээг 61.6 сая төгрөгөөр мэдээлээгүй зөрчил илэрсэн.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна..

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

4. Аудитын илрүүлэлт

4.1 Засварын үеийн санхүүгийн тайлангийн аудит

Завсрын үеийн аудитад хамрагдаагүй байна.

4.2 Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудит

Аудитаар нийт 4.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 2.7 сая төгрөгийн алдааг залруулж, 2.1 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлсэн.

4.2.1 Залруулсан алдаа

1.1. Илрүүлэлт:

- ✓ Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 1.3 сая төгрөгөөр дутуу илэрхийлэгдсэн
- ✓ Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам зөрчин, 1.4 сая төгрөгийн нэмэгдлийг илүү тооцоолж олгосон.

1.2. Шийдвэрлэлт

- ✓ Санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдээгдэлтэй нийцээгүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 дэх заалтыг зөрчиж байгаа тул дутуу илэрхийлэгдсэн элэгдлийн зардлыг залруулсан.
- ✓ Ажилтнуудад илүү олгосон төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг авлага үүсгэн залруулсан.

4.2.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй.

4.2.3 Албан шаардлага

Албан шаардлага хүргүүлээгүй.

4.2.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал**

1.1. Илрүүлэлт:

- ✓ 2.1 сая төгрөгийн зардлын и-баримтыг бүрэн бүрдүүлээгүй;

1.2. Өгсөн зөвлөмж:

- ✓ Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах;
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"; Татварын ерөнхий хуулийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ."; Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ."; гэж заасныг хэрэгжүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
	Орон нутгийг судлах музей	3	4.8	2	2.7					1	2.1
Дүн		3	4.8	2	2.7					1	2.1